



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024 04 09 № 08

Сургуулийн орчинд үйлдэгддэг  
зарим гэмт хэргийн талаар

Боловсролын салбарт үе тэнгийнхний дээрэлхэлт, гадуурхалт болон бусад гэмт хэргийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдад хандаж 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр асуулт тавьсан. Асуултын хариуд боловсролын байгууллагад гарч буй үе тэнгийнхний дээрэлхэлт, гадуурхалт болон ялангуяа гэмт хэргийн шинжтэй зөрчлийг бууруулах талаар бодлого, журам, чиглэл гарган, үе шаттай ажлууд хийж байгаа талаар дурдсан. Улсын Их Хурлын гишүүн миний бие иргэд сонгогчид, боловсролын байгууллага, эцэг эхчүүдийн төлөөлөлтэй уулзаж санал солилцох үед сургуулийн орчныг аюулгүй байлгах, үе тэнгийнхний дээрэлхэлт, мансууруулах бодис, сэтгэцэт нөлөөт бодис, утаат болон электрон тамхины хэрэглээ гэх зэрэг олон сэдэв хөндөгдсөн. Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт “Боловсролын сургалтын байгууллага нь болзошгүй эрсдэл, гамшгаас хамгаалах аюулгүй байдлыг хангасан, суралцагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн орчин бүрдүүлсэн байна.” гэж хуульд заасан байдаг.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Сургуулийн орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, төрөл, хэлбэр тэдгээрийн тоон мэдээлэл;

2.Үе тэнгийнхний дээрэлхэлт, гадуурхалтыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажил, үр дүн;

3.Ерөнхий боловсролын сургуулиар хязгаарлагдалгүй бусад боловсролын шат шатны сургалтын байгууллагуудад гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, төрөл, хэлбэр, тэдгээрийн талаар тоон мэдээлэл;

4.Бүх шатны боловсролын байгууллагуудын орчны эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ хийсэн эсэх, түүнийг сайжруулахад авсан арга, хэмжээний талаар сүүлийн 3 жилийн ажлын тайлан;

2024090908

5.Боловсролын байгууллагуудад ажиллаж буй сэтгэл зүйч, нийгмийн ажилтны санал гомдол, Ерөнхий боловсролын сургуулиуд сэтгэл зүйч, нийгмийн ажилтанаар бүрэн хангагдсан эсэх, мөн ажил үүргээ гүйцэтгэхэд тулгарч буй саад бэрхшээлийн талаарх мэдээлэл;

6.Оюутан, сурагчдын хүмүүжил, зан үйлд нөлөөлөх, тэдгээрт хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох мөн цахим орчныг зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулж байгаа талаарх мэдээлэл;

7. Оюутан, сурагчдын мансууруулах бодистой холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн тоо, баримт түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын талаарх тайлан, мэдээлэл зэрэг болно.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



С.ОДОНТУЯА